



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 07 сарын 21 өдөр

Дугаар СХШ/2025-ӨГ-02

Сүхбаатар сум

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын  
Үйл ажиллагаанд албан хаагчдаас гаргасан өргөдөл дагуу хийсэн  
Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүнгийн тухай

2025.07.21

№ СХШ/2025-ӨГ-02

Сэлэнгэ аймаг

Нэг: Хяналт шалгалтын үндэслэл, зорилго

1.1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 16.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5, 6 дугаар зүйл, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг тус тус үндэслэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ.

1.2. “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын албан хаагчдаас гаргасан тус байгууллагын удирдлагын үйл ажиллагаа болон санхүүгийн зөрчилд хяналт шалгалт хийлгүүлэх өргөдлийг аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 01/858 дугаартай албан бичгээр ирүүлсний дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр баталсан төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай СХШ/2025-ӨГ-02 дугаар удирдамжийн хүрээнд санхүү төсвийн гүйцэтгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт гаргах зорилготой.

1.3. Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2022-2025 оны эхний 2 дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааг хамруулав. Үүнд:

1.4. Дээрх дурдсан гомдолтой холбоотойгоор санхүүгийн хяналт шалгалтыг дараах асуудлын хүрээнд шалгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд.

- ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа зорилтот түвшнийг хангаж санхүүгийн үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангасан эсэх
- Батлагдсан төсвийг зохистой удирдаж зориулалтын дагуу зарцуулсан байдал
- Авлага, өр төлбөрийн өсөлт, бууралт, насжилт, барагдуулалт данс бүртгэлд үнэн зөв тусгасан байдал.
- Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

- Санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг стандарт, заавар аргачлалын дагуу үнэн зөв хөтөлж бүрдүүлсэн байдал
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт
- Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал
- Албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, түүнийг дүгнэж үр дүнг тооцсон эсэх
- Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал.

1.5. Санхүүгийн хяналт шалгалтыг ажлын хэсгийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга, СХШУАБ Т.Одсүрэн, ахалж гишүүдэд дотоод аудитор Г.Дорждэрэмийн хамт 2025 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс 07 дугаар сарын 18-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

1.6. Шалгалтад Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын удирдлага, санхүүгийн ажилтан, холбогдох ажилтнуудаас хяналт шалгалттай холбоотой өргөдөлд дурдагдсан асуудлын талаар нэмэлт баримт материал тайлбар тодруулга авч байгууллагын 2022-2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн холбогдох баримтуудыг хамруулаа.

**Хоёр: Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал, шалгуулагчийн санал хүсэлт**

**2.1. ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа зорилтот түвшнийг хангаж санхүүгийн үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангасан эсэх**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Мандал Энерго” ОНӨААТҮГ -ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүргийн дагуу сумын ИТХ-ын тогтоолоор жил бүр батлуулан үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэн ирсэн байна. Үүнд:

*Хүснэгт 1.*

д/д	Огноо	Тогтоолын дугаар	Тогтоолын нэр	Төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээ
1	2022.02.24	43	“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан, 2022 оны төлөвлөгөө, төсвийн тухай	Хангалттай
2	2023.01.31	93	Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны төлөвлөгөө, төсвийн тухай	Хангалттай
3	2024.01.29	135	“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөө, төсвийн тухай	Хангалттай
4	2025.01.30	20	Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны төлөвлөгөө, төсвийн тухай	Хангалттай

Мандал сумын ИТХ-аас жил бүр тус үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнг, хэлэлцэн үнэлж дараа онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг баталж байгаа боловч хурлын тогтоолоор батлагдсан төсвийн гүйцэтгэлд тавих хяналт сул 2023, 2024 оны үнэлгээг бодитоор дүгнээгүй байна.

Үүнийг 2021-2025 оны эдийн засгийн зорилтод түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн дараах нэгтгэл дүнгээр харуулав.

Хүснэгт 2.

/Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт		Тайлант онууд				
		2021	2022	2023	2024	2025
Нийт орлого	Төлөвлөгөө	930,911.4	1,121,193.2	1,525,027.3	1,598,188.5	1,785,032.8
	Гүйцэтгэл	992,524.1	1,160,770.9	1,577,571.2	1,696,724.9	1,038,411.6
	зөрүү	<b>61,612.7</b>	<b>39,577.7</b>	<b>52,543.9</b>	<b>98,536.4</b>	<b>(746,621.2)</b>
	хувь	106.6	103.5	103.4	106.2	58.2
Нийт зарлага	Төлөвлөгөө	917,067.7	1,104,360.3	1,488,379.3	1,564,136.8	1,765,797.4
	Гүйцэтгэл	957,047.3	1,140,953.1	1,560,044.4	1,727,626.0	1,020,916.3
	зөрүү	<b>39,979.6</b>	<b>36,592.8</b>	<b>71,665.1</b>	<b>163,489.2</b>	<b>(744,881.1)</b>
	хувь	104.4	103.3	104.8	110.5	57.8
Ашиг/ алдагдал	Төлөвлөгөө	<b>13,843.7</b>	<b>16,832.9</b>	<b>36,648.0</b>	<b>34,051.7</b>	<b>19,235.4</b>
	Гүйцэтгэл	<b>35,476.8</b>	<b>19,817.8</b>	<b>17,526.8</b>	<b>(30,901.1)</b>	<b>17,495.3</b>
	Зөрүү	<b>21,633.1</b>	<b>2,984.9</b>	<b>(19,121.2)</b>	<b>(64,952.8)</b>	<b>(1,740.1)</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлан мэдээ

Мандал Энерго" ОНӨААТҮГ -нь 2021 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг бүрэн хангаж 21,633.1 мянган төгрөгөөр 2022 онд 2,984.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн ашгийг давуулан ашигтай ажилласан байна.

Харин 2023 онд сумын ИТХ-аар батлуулсан эдийн засгийн зорилтод түвшин 36,648.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан боловч бодит гүйцэтгэлээр 19,121.2 мянган төгрөгөөр 2024 онд 34,051.7 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан ч гүйцэтгэлээр 64,952.8 мянган төгрөгөөр ашигт ажиллагаа буурсан байна.

Өөрөөр хэлбэл жил бүр орлого 3-6 хувиар өсөн нэмэгдэж байхад батлагдсан зардлыг мөн 3-10 хувиар хэтрүүлж үйлдвэрийн газрын ашигт ажиллагаа, үр өгөөжийг бууруулж байна.

Эдийн засгийн зорилтод түвшний 2024 оны батлагдсан төсвийн хэтэрсэн зардлыг ангиллаар дараах дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.

/Мянган төгрөгөөр/

№	Зардлын төрөл	2024 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт/ хэмнэлт	гүйцэтгэл хувь
1	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	3,000.0	18,174.1	(15,174.1)	605.8
2	Түүхий эд материал	505,454.7	631,490.3	(126,035.6)	124.9
3	Гэрэл цахилгаан	72,186.0	111,309.6	(39,123.6)	154.2
4	Цэвэр ус худалдан авах зардал	71,635.7	76,483.4	(4,847.7)	106.8
5	Шатах тослох материал	32,708.6	36,639.6	(3,931.0)	112.0
6	ҮХ-ийн элэгдлийн зардал	61,569.6	82,075.0	(20,505.4)	133.3
7	Аудит, Тусгай Зөвшөөрлийн төлбөр	5,440.9	15,502.0	(10,061.1)	284.9
8	Нэг удаагийн тэтгэмж шагнал	34,985.0	51,079.1	(16,094.1)	146.0
9	Бага үнэтэй түргэн хэрэглэгдэх зүйл	2,192.5	9,361.9	(7,169.4)	427.0
10	Жижиг эд хогшил багаж хэрэгсэл	1,450.0	6,115.2	(4,665.2)	421.7
11	Хангамжийн материал, засвар	3,150.5	12,829.3	(9,678.8)	407.2
12	ХАБЭА-н зардал	9,804.5	12,787.5	(2,983.0)	130.4
13	Засварын зардал	5,723.0	8,479.0	(2,756.0)	148.2
14	Сургалт, спорт арга хэмжээний зардал	7,900.0	13,669.9	(5,769.9)	173.0
<b>Зардлын дүн</b>		<b>817,201.0</b>	<b>1,085,995.9</b>	<b>(268,794.9)</b>	<b>132.9</b>

Тус үйлдвэрийн газрын 2024 оны үйл ажиллагааны үр дүнгээр 30,901.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж өөрийгөө санхүүжүүлж чадаагүй нь дээрх хүснэгтэд дурдсан зардлын хэтрэлт нь дараах дараах нөхцөл байдлаас шалтгаалж байна. Үүнд

- ✓ *Батлагдсан төсвийг зохистой удирдаж төлөвлөгдсөн зардлыг хэтрүүлэхгүй байх боломжтой байсан атал гадаад хүчин зүйлээс шалтгаалсан гэрэл цахилгаан, цэвэр ус, шатахуун, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас бусад зардлыг 24.8 хувиас 6 дахин хэтрүүлсэн.*
- ✓ *Үйлдвэрийн газрын үр ашгийг дээшлүүлэх, зардал бууруулах, бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй.*
- ✓ *Гүйцэтгэх удирдлагын зүгээс батлагдсан төсвийн зардлыг хэтрүүлэхгүй, санхүүгийн сахилга батыг сахиулж, үр нөлөөтэй байх удирдлагын менежментийг хангалтгүй хэрэгжүүлсэн.*
- ✓ *Сүүлийн 5 жилийн хугацаанд төлөвлөсөн орлогын хэмжээ 3-6 хувиар давуулан биелүүлсэн атлаа олсон орлогын хэмжээгээр зарцуулсан.*
- ✓ *2024 оны төлөвлөсөн зардлын нийт хэтрэлтийн 74.5 хувь болох 200,387.2 мянган төгрөгийн зарцуулалт нь өөрсдийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай буюу ашигтай ажиллах боломжийг алдсан байна.*

## **2.2. Батлагдсан төсвийг зохистой удирдаж зориулалтын дагуу зарцуулсан байдал**

Тус үйлдвэрийн газрын даргаар 2022-2024 онуудад ажиллаж байсан Д.Хадбаатар нь байгууллагын 40 ажилтан сурч боловсроход зориулсан сургалтын зардлаас 8,000.0 мянган төгрөгийг өөртөө давуу байдал олгож санхүүгийн шийдвэр гарган зарцуулсан гэх асуудлыг шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

- ✓ *Хяналт шалгалтын явцад дээрх асуудлыг баримтаар тулган баталгаажуулахад Төрийн аудитын байгууллагаас тус газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Байгууллагын төсөвт тусгагдсан гэх үндэслэлээр нөхцөл, шаардлага, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон дагалдах гэрээгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр тус газрын дарга Д.Хадбаатарын ШУТИС-ийн сургалтын төлбөр 7,769.5 мянган төгрөгийг шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан зөрчилд “Төлбөр барагдуулах тухай” акт тогтоосон байна.*
- ✓ *Нөгөөтэйгөөр сумын ИТХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 135 дугаар тогтоолоор баталсан тус үйлдвэрийн газрын санхүүгийн төлөвлөгөөнд сургалт, спортын арга хэмжээний зардлыг 7,200.0 мянган төгрөгөөр баталсан атал гүйцэтгэлээр 13,669.9 мянган төгрөгийг зарцуулагдсан нь өөрт давуу байдал үүсгэж батлагдсан зардлыг хэтрүүлсэн нь санхүүгийн хяналт шалгалтаар тогтоогдож байна.*
- ✓ *Дээрх “Төлбөр барагдуулах тухай” актын хэрэгжилт 2025 оны 6 дугаар сарын байдлаар 1,000.0 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлсэн байна.*

- ✓ Төрийн аудитын байгууллагаас төлбөрийн актын хэрэгжилт тооцох хугацааг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл байхаар тогтоосон бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

### 2.3. Авлага, өр төлбөрийн өсөлт, бууралт, насжилт, барагдуулалт данс бүртгэлд үнэн зөв тусгасан байдал.

Мандал Энерго" ОНӨААТҮГ-ын сүүлийн 4 жилийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг дараах хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 4.

/Мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025 оны эхний хагас жил	Насжилт
1	Авлага	70,253.1	56,043.3	65,209.8	42,680.0	Нийт авлагын дүнгээс 1,019,5 мянган төгрөг нь 2-оос дээш жилийн насжилттай авлага байна.
2	Өр төлбөр	86,257.0	177,613.9	166,607.8	163,668.3	1 жилийн доторх богино хугацаат өр төлбөр байна.

Д.Хадбаатар нь Мандал Энерго" ОНӨААТҮГ-ын захирлаар 2 жил гаран хугацаанд ажиллахдаа арилжааны банканд 90,000.0 мянган төгрөгийн, данснаас гадуурх 160,000.0 мянган төгрөгийн өр төлбөртэй үлдээсэн гэх асуудлыг шалгахад тус асуудал нь бодит бус баримтаар нотлогдохгүй байна.

Мандал Энерго" ОНӨААТҮГ-ын 2023 оны нийт өр төлбөр 177,613.9 мянган төгрөг болж өмнөх оноос 91,356.9 мянган төгрөгөөр өссөн нь санхүүгийн анхан шатны баримт, бүртгэл, тайлан, аудитын дүгнэлт зэргээр нотлогдох бөгөөд нүүрс нөөцөлж зээлээр худалдан авалт хийснээс байгууллагад өгөх өглөг буюу нүүрсний төлбөр 66,346.3 мянган төгрөгөөр, татварын өр төлбөр 6,496.6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт өр төлбөрийн 10.3 хувийг буюу 18,332.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн, 27.4 хувийг буюу 48,498.6 мянган төгрөгийн татварын, 57.4 хувийг буюу 102,130.9 мянган төгрөгийн дансны, 4.7 хувийг буюу 8,162.8 мянган төгрөгийг бусад, 0.2 хувийг буюу 489.6 мянган төгрөгийн цалингийн өр төлбөр эзэлж байна.

2024 онд Өр төлбөр дансны үлдэгдэл 166,607.8 мянган төгрөг болж өмнөх оноос 11,006.1 мянган төгрөгөөр буурсан нь Шивээ овоо ХХК, Ширхэнцэг арвин хишиг ХХК-д төлөх өглөг буурсантай холбоотой байна.

Авлагын дансны ангиллыг 2022-2025 оноор нэгтгэн дараах хүснэгтээр харуулав

Хүснэгт 5.

/Мянган төгрөгөөр/

№	Авлагын данс ангиллаар	2022	2023	2024	2025	Нийт авлагын дүнд эзлэх хувь
1	Халаалтын авлага	36,755.3	41,646.8	24,014.7	34,607.8	81.1
2	Усны авлага	21,846.5	3,585.1	3,904.3	1,122.7	2.6
3	СӨХ-ийн авлага	2,643.0	2,193.0	-	-	-
4	Засвар үйлчилгээний авлага	893.7	560.7	1,553.7	1,109.8	2.6
5	Худгийн картын авлага	830.0	1,522.5	1,300.5	1,425.0	3.3
6	Татвар, НДШ-ийн авлага	2,055.1	1,829.7	28,487.6	1,408.0	3.3
7	Бусад авлага	5,229.5	4,705.5	5,949.0	3,006.7	7.0
<b>Нийт авлагын дүн</b>		<b>70,253.1</b>	<b>56,043.3</b>	<b>65,209.8</b>	<b>42,680.0</b>	<b>34.5</b>

Авлагын дансны ангиллыг 2022-2025 оны эхний хагас жилийн байдлаар харьцуулан харвал 2025 оны эхний хагас жилийн байдлаар авлага өмнөх оноос 34.5 хуваар буурсан үзүүлэлтэй, нийт авлагын 81.1 хувийг дулааны авлага эзэлж байна.

**Өглөгийн дансны ангиллыг 2022-2025 оноор нэгтгэн дараах хүснэгтээр харуулав**

Хүснэгт 6.

/Мянган төгрөгөөр/

№	Өглөгийн данс ангиллаар	2022	2023	2024	2025	Нийт өглөгийн дүнд эзлэх хувь
1	Байгууллагад өгөх өглөг	10,253.0	14,027.2	812.2	9,447.7	5.8
2	Нүүрсний өглөг	25,531.6	88,103.7	83,149.4	48,500.0	29.6
3	Ажилчидтай холбоотой өглөг	-	-	636.2	657.1	0.4
4	Усны өглөг	-	-	-	16,839.3	10.3
5	Бусад өглөг	-	-	-	2,200.0	1.3
6	Цалингийн өглөг	427.8	489.6	504.1	12,146.9	7.4
7	Татварын өр	42,002.0	48,498.6	24,594.5	41,173.8	25.2
8	НДШ-ийн өглөг	500.0	18,332.1	50,430.1	26,202.3	16.0
9	Урьдчилж орсон орлого	7,542.6	8,162.8	6,481.3	6,501.3	4.0
<b>Нийт өглөгийн дүн</b>		<b>86,257.0</b>	<b>177,613.9</b>	<b>166,607.8</b>	<b>163,668.3</b>	<b>1.8</b>

Өглөгийн дансны ангиллыг 2022-2025 оны эхний хагас жилийн байдлаар харьцуулан харвал 2025 оны эхний хагас жилийн байдлаар өглөг өмнөх оноос 1.8 хуваар буурсан үзүүлэлтэй, нийт өглөгийн дансанд нөлөөлж байгаа дараах өглөгүүд байна. Үүнд:

Нүүрсний төлбөр 29.6 хувийг, Усны төлбөр 10.3 хувийг, татварын өр төлбөр 25.2 хувийг, НДШ-ийн өр төлбөр 16.0 хувийг цалингийн өглөг 7.4 хувийг тус тус эзэлж байна

**2.4. Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт**

ААТҮГ нь барилга байгууламж 140,860.4 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 35,000.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 286,083.8 мянган төгрөг, тавилга эд хогшил 13,008.8 мянган төгрөг, Компьютер 7,919.6 мянган төгрөг, Тавилга эд хогшил 13,008.8 мянган төгрөг, Инженерийн шугам сүлжээ 512,325.0 мянган төгрөг, программ хангамж 2,277.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 83,551.0 мянган төгрөгөөр өссөн нь 3,254.3 мянган төгрөгийн Компьютер дансанд өртөг бүхий компьютер, 261.0 мянган төгрөг Тавилга эд хогшил, 97,345.0 мянган төгрөгийн Машин тоног төхөөрөмж авснаас шалтгаалсан байна.

**Үндсэн хөрөнгийн 2022-2025 оны хөдөлгөөнийг харуулав**

Хүснэгт 7.

/Мянган төгрөгөөр/

он	Хөрөнгийн данс	Хөрөнгийн нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	хасагдсан	Эцсийн үлдэгдэл
2022 он	2003-2000	Компьютер	7,362.6	-	295.4	7,067.3
	2003-1000	Тавилга эд хогшил	18,325.2	261.0	1,349.0	17,237.2
	2002-2000	Тээврийн хэрэгсэл	59,350.0	-	45,984.0	13,366.0
	2002-1000	Машин тоног төхөөрөмж	192,646.1	1,690.0	20,754.4	173,581.7
	2001-1000	Барилга, байгууламж	271,447.8	-	24,922.6	246,525.2
	2004-1000	Инженерийн шугам сүлжээ	667,395.8	41,354.7	-	708,750.5
	2106-1000	Компьютерын программ хангамж	-	5,940.0	891.0	5,049.0
	<b>Нийт</b>			<b>1,216,527.5</b>	<b>49,245.7</b>	<b>94,196.3</b>

2023 он	2003-2000	Компьютер	7,067.3	-	1,051.8	6,015.5
	2003-1000	Тавилга эд хогшил	17,236.8	-	7,690.3	9,546.6
	2002-2000	Тээврийн хэрэгсэл	35,000.0	-	35,000.0	-
	2002-1000	Машин тоног төхөөрөмж,	239,253.0	15,463.6	102,270.0	152,446.6
	2001-1000	Барилга, байгууламж	271,447.8	-	126,081.9	145,365.8
	2004-1000	Инженерийн шугам сүлжээ	708,750.5	76,073.4	219,061.2	565,762.7
	2106-1000	Компьютерын программ хангамж	5,940.0	-	2,079.0	3,861.0
	<b>Нийт</b>		<b>1,284,695.3</b>	<b>91,537.0</b>	<b>493,234.2</b>	<b>882,998.1</b>
2024 он	2003-2000	Компьютер	7,362.6	-	2,223.7	5,138.9
	2003-1000	Тавилга эд хогшил	17,975.8	1,000.0	10,323.0	8,652.9
	2002-2000	Тээврийн хэрэгсэл	35,000.0	-	35,000.0	-
	2002-1000	Машин тоног төхөөрөмж,	192,646.1	67,361.3	20,754.4	187,355.3
	2001-1000	Барилга, байгууламж	161,786.1	-	19,517.8	142,268.3
	2004-1000	Инженерийн шугам сүлжээ	767,054.3	10,880.7	245,198.8	532,736.2
	2106-1000	Компьютерын программ хангамж	5,940.0	-	3,168.0	2,772.0
	<b>Нийт</b>		<b>1,187,765.0</b>	<b>79,242.0</b>	<b>336,185.7</b>	<b>878,923.6</b>
2025 он	2003-2000	Компьютер	7,362.6	3,254.3	2,697.3	7,919.6
	2003-1000	Тавилга эд хогшил	18,325.2	261.0	5,577.5	13,008.8
	2002-2000	Тээврийн хэрэгсэл	35,000.0	-	35,000.0	-
	2002-1000	Машин тоног төхөөрөмж,	335,591.5	97,345.0	146,852.7	286,083.8
	2001-1000	Барилга, байгууламж	161,786.1	-	20,925.8	140,860.4
	2004-1000	Инженерийн шугам сүлжээ	777,935.0	-	265,610.0	512,325.0
	2106-1000	Компьютерын программ хангамж	5,940.0	-	3,663.0	2,277.0
	<b>Нийт</b>		<b>1,341,940.5</b>	<b>100,860.3</b>	<b>480,326.2</b>	<b>962,474.6</b>

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын захирлын 2024 оны А/23 дугаар тушаалаар өмч хамгаалах зөвлөлийг байгуулж жилийн ажлын төлөвлөгөөг гарган ажилласан байна. Тус зөвлөл нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавихаар төлөвлөсөн ч чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, үндсэн хөрөнгийн данснаас актлах хөрөнгийн санал, дүгнэлт гаргах хэмжээнд ажилласан байна.

Монгол Улсын төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох "Хур Систем"-д тус ОНӨААТҮГ-ын тээврийн хэрэгслийн бүртгэлд XCMG XG951, NISSAN Mistral, ЗИЛ MMZ-555, Foton BJ3251, Liu Gong CLG418 маркийн хүнд машин механизм болон PHINOCFROS маркийн трактор бүртгэлтэй байгаа атал байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд зөвхөн PHINOCFROS маркийн трактор бүртгэлтэй байна.

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн газар дээр нь тулган баталгаажуулахад одоо ашиглагдаж байгаа Foton BJ3251, Liu Gong CLG418 маркийн хүнд машин механизм, PHINOCFROS маркийн трактор байна.

Үүнээс гадна сумын ИТХ-ын тогтоолоор 2021 онд Тохилог хараа ААТҮГ-т ЗИЛ MMZ-555, Liu Gong CLG418 маркийн хүнд машин механизмыг шилжүүлсэн атал хур цахим системийн мэдээлэлд тус үйлдвэрийн газрын нэр дээр бүртгэлтэй хэвээр байгаа алдааг залруулж хөрөнгийн цахим болон дансны бүртгэлийн зөрүүг гарган үнэн зөв тайлагнах, мөн өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, шаардлагатай байна.

## **2.5. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт**

Мандал Энгеро” ОНӨААТҮГ нь нүүрс болон шатахууны худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 8.

/Мянган төгрөгөөр/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл,	Тендер шалгаруулалтын арга	Батлагдсан төсөв			
			2022	2023	2024	2025
1	Нүүрс	НТШ	358,242.6	483,641.6	505,454.7	639,677.0
2	Шатахуун	ХА	21,192.8	60,460.7	32,708.6	76,483.4
	<b>Нийт төсөвт өртөг</b>		<b>379,435.4</b>	<b>544,102.3</b>	<b>538,163.3</b>	<b>716,160.4</b>

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулдаг боловч нүүрсний худалдан авалтын тендерт оролцогч тал байхгүй гэх шалтгаанаар 2022-2025 онуудад шууд худалдан авалтыг гүйцэтгэсээр байна.

Энэ нь нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой... байх зарчмыг баримтална” Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1: “Шууд худалдан авч болох төсөвт хязгаар: Бараа-20,0 сая төгрөг”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

**2022-2025 онд худалдан авсан нүүрсний тооцоо**  
/бэлтгэн нийлүүлэгчээр/

Хүснэгт 9.

/Мянган төгрөгөөр/

д/д	Бэлтгэн нийлүүлэгч	огно о	Нүүрсний				Шилжүүлсэн			Эцсийн үлдэгдэл
			Эхний үлдэгдэл /мян.төг/	Нэгжийн үнэ /мян.төг/	Тоо хэмжээ /тн/	Нийт үнэ /мян.төг/	Нүүрсний үнэ	Тээврийн зардал	Нийт	
1	Шивээ Овоо ХК	2022	46,253.2	45.2	5,037.0	227,883.9	195,410.0	66,586.3	261,996.3	12,140.8
	Шивээ Овоо ХК				1.0	284.8	284.8			
	Вагон тавилт, таталт (УБТЗХНН)					16,773.5		16,773.5	16,773.5	-
2	Критек ХХК	2022		45.4	2,681.0	121,623.8	72,310.1	35,923.0	108,233.1	13,390.8
	Вагон тавилт, таталт (УБТЗХНН)					8,927.9		8,927.9	8,927.9	-
	<b>Нийт</b>		<b>6,253.2</b>	<b>90.6</b>	<b>7,719.0</b>	<b>375,494.0</b>	<b>268,004.9</b>	<b>128,210.7</b>	<b>395,930.8</b>	<b>25,531.6</b>
3	Шивээ Овоо ХК	2023	12,140.8	60.0	4,041.8	242,573.8	117,970.9	69,225.0	187,195.9	67,518.7
	Вагон тавилт, таталт (УБТЗХНН)					18,839.0		18,839.0	18,839.0	-
4	Критек ХХК	2023	13,390.8	61.5	4,806.0	295,667.1	239,787.4	69,270.5	309,057.9	-
	Вагон тавилт, таталт (УБТЗХНН)					22,401.0		22,401.0	22,401.0	-
5	О.Мижиддорж	2023		84.7	481.0	40,746.0	40,746.0		40,746.0	-
6	Ширхэнцэг арвин хишиг	2023		115.0	479.0	55,085.0	34,500.0		34,500.0	20,585.0
	<b>Нийт</b>		<b>5,531.6</b>	<b>321.2</b>	<b>9,807.8</b>	<b>675,311.8</b>	<b>433,004.3</b>	<b>179,735.5</b>	<b>612,739.8</b>	<b>88,103.7</b>
7	Багануур ХК	2024		59.8	2,273.9	135,989.2	135,989.2		135,989.2	-
	Тээврийн зардал, вагон тавилт, таталт, бусад (УБТЗХНН)					45,973.3		45,973.3		
8	Шивээ Овоо ХК	2024	67,518.7	67.4	3,279.4	220,974.2	162,449.0	61,370.7	223,819.7	64,673.2

	Вагон тавилт, таталт (УБТЗХНН)				18,531.2		18,531.2	18,531.2	-
9	Ширхэнцэг арвин хишиг	20,585.0	100.0	3,006.5	300,567.9	302,676.7		302,676.7	18,476.2
10	Шарын гол ХК		88.0	38.8	3,410.0	3,410.0	-	3,410.0	-
<b>Нийт</b>		<b>8,103.7</b>	<b>315.2</b>	<b>8,598.6</b>	<b>725,445.8</b>	<b>604,524.9</b>	<b>125,875.2</b>	<b>684,426.8</b>	<b>83,149.4</b>
11	Багануур" ХК	-	83.9	193.1	16,201.7	12,744.6	3,457.1	16,201.7	-
12	Шивээ Овоо ХК	64,673.2	76.1	807.0	61,398.9	62,211.2	15,361.0	77,572.2	48,500.0
	Вагон тавилт, таталт (УБТЗХНН)								
13	Ширхэнцэг арвин хишиг	18,476.2	94.5	3,276.0	309,484.3	327,960.5		327,960.5	-
<b>Нийт</b>		<b>3,149.4</b>	<b>254.5</b>	<b>4,276.1</b>	<b>387,752.6</b>	<b>402,916.3</b>	<b>18,818.1</b>	<b>421,734.4</b>	<b>48,500.0</b>

"Мандал Энержо" ОНӨАТҮГ- нь дээрх хүснэгтэд дурдсан бэлтгэн нийлүүлэгчдээс 2022 онд 7,719 тонн нүүрсийг 375,494.0 мянган төгрөгөөр, 2023 онд 9,807.8 тонн нүүрсийг 675,311.8 мянган төгрөгөөр, 2024 онд 8,598.6 тонн нүүрсийг 725,445.8 мянган төгрөгөөр, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 4,300.1 тонн нүүрсийг 387,752.6 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Мандал Энержо" ОНӨАТҮГ-ын 2022-2025 онд худалдан авсан нүүрсний тээвэргүй болон тээвэртэй үнийн харьцуулсан судалгааг дараах хүснэгтээр харуулав.

### Нүүрсний үнийн харьцуулсан судалгаа

Хүснэгт 10.

/Мянган төгрөгөөр/

Он	Үзүүлэлт	Шивээ Овоо ХК	Критек ХХК	Багануур ХК	Шарын гол ХК	О.Мижид-дорж	Ширхэнцэг арвин хишиг ХХК	Нийт худалдан авалт
<b>1тн Нүүрс тээвэртэй</b>		<b>48.6</b>	<b>48.7</b>					
<b>1тн Нүүрс тээвэргүй</b>		<b>32.1</b>	<b>32.0</b>					
2022	Тоо хэмжээ /тн/	5,038.0	2,681.0					7,719.0
	Нүүрсний үнэ	161,582.4	85,700.8					247,283.3
	Тээврийн зардал	66,586.3	35,923.0					102,509.3
	Ачилт буулгалт, бусад	16,773.5	8,927.9					25,701.4
	<b>Нийт үнэ</b>	<b>244,942.2</b>	<b>130,551.7</b>					<b>375,494.0</b>
<b>1тн Нүүрс тээвэртэй</b>		<b>64.69</b>	<b>66.18</b>			<b>84.71</b>	<b>115.00</b>	
<b>1тн Нүүрс тээвэргүй</b>		<b>42.90</b>	<b>45.67</b>			<b>84.71</b>	<b>115.00</b>	
2023	Тоо хэмжээ /тн/	4,041.0	4,806.0			481.0	479.0	9,807.0
	Нүүрсний үнэ	173,348.8	219,469.5			40,746.0	55,085.0	488,649.3
	Тээврийн зардал	69,225.0	76,197.6					145,422.6
	Ачилт буулгалт, бусад	18,839.0	22,401.0					41,239.9
	<b>Нийт үнэ</b>	<b>261,412.8</b>	<b>318,068.1</b>			<b>40,746.0</b>	<b>55,085.0</b>	<b>675,311.8</b>
<b>1тн Нүүрс тээвэртэй</b>		<b>73.03</b>		<b>80.02</b>	<b>88.00</b>		<b>99.97</b>	
<b>1тн Нүүрс тээвэргүй</b>		<b>48.67</b>		<b>59.80</b>	<b>88.00</b>		<b>99.97</b>	
2024	Тоо хэмжээ /тн/	3,279.4		2,273.9	38.8		3,006.5	8,598.6
	Нүүрсний үнэ	159,600.5		135,989.2	3,410.0		300,567.9	599,567.7
	Тээврийн зардал	61,373.7		33,123.9				94,497.6
	Ачилт буулгалт, бусад	18,531.2		12,849.4				31,380.6
	<b>Нийт үнэ</b>	<b>239,505.4</b>		<b>181,962.5</b>	<b>3,410.0</b>			<b>725,445.8</b>
<b>1тн Нүүрс тээвэртэй</b>		<b>76.91</b>		<b>83.90</b>			<b>94.45</b>	

1тн Нүүрс тээвэргүй		57.05		66.00		94.45	
2025	Тоо хэмжээ /тн/	807.0		193.1		3,276.7	4,276.8
	Нүүрсний үнэ	46,037.9		12,744.6		309,484.3	368,266.9
	Тээврийн зардал	15,361.0		3,233.7			18,594.7
	Ачилт буулгалт, бусад	667.6		223.4			891.0
	<b>Нийт үнэ</b>	<b>62,066.5</b>		<b>16,201.7</b>		<b>309,484.3</b>	<b>387,752.6</b>

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын нүүрсний худалдан авалтын сүүлийн 4 жилийн байдлаар 1тонн тутмын тээвэртэй болон тээвэргүй уурхайн үнийг бэлтгэн нийлүүлэгч бүрээр харьцуулан дүн шинжилгээ хийхэд дараах үр дүнг гарч байна. Үүнд:

- 2022-2025 онуудад 2-4 бэлтгэн нийлүүлэгчээс авснаас байнгын тасралтгүй нийлүүлэгч нь Шивээ овоо ХХК тасралтгүй хамтран ажилласан байна.
- Дээрх хүснэгтээс бэлтгэн нийлүүлэгчдийн нүүрсний үнийн уурхайн тээврийн зардал ороогүй болон тээврийн зардал нэмэгдсэн 1тонн тутмын үнийг 2023 онд Шивээ овоо ХХК, Критек ХХК,-ийн тээврийн зардал шингэсэн 1 тонн тутмын дундаж үнэ 65.0-80.0 мянган төгрөг байхад иргэн О.Мижиддорж нь болон “Ширхэнцэг арвин хишиг” ХХК-ийн тээврийн зардал шингэсэн 1 тонн тутмын үнэ 84.7-115.0.0 төгрөгөөр худалдаж авснаас 960 тонн нүүрснээс 1 тонн тутамд 38.4 мянган төгрөг буюу 36,881.7 мянган төгрөгийн нүүрсний зардлыг хэмнэх алдагдсан боломжийн өртөг байна. /О.Мижиддорж нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд 3769747 регистрийн дугаартай “Ширхэнцэг арвин хишиг” ХХК -ыг байгуулж гүйцэтгэх захирлаар бүртгүүлсэн талаарх мэдээллийг дурдав./
- 2024 онд Багануур ХК-аас 80.0 мянган төгрөгөөр Шарын гол ХК- аас 88.0 мянган төгрөгөөр, Ширхэнцэг арвин хишиг ХХК-аас 100.0 мянган төгрөгөөр нийт 5319.2 тонн нүүрсийг худалдан авалгүйгээр Шивээ овоо ХХК-аас тээвэр, ачилт, буулгалтын зардлын өртөг шингэсэн тонн тутмыг 76.1 мянган төгрөгөөр худалдан авч 64,362.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэх алдагдсан боломжийн өртөг байна.
- 2025 онд Багануур ХК-аас 83.9 мянган төгрөгөөр, Ширхэнцэг арвин хишиг ХХК-аас 94.5 мянган төгрөгөөр нийт 3,469.8 тонн нүүрсийг худалдан авалгүйгээр Шивээ овоо ХХК-аас тээвэр, ачилт, буулгалтын зардлын өртөг шингэсэн тонн тутмыг 76.1 мянган төгрөгөөр худалдан авч 61,797.5 мянган төгрөгийн зардлыг хэмнэх алдагдсан боломжийн өртөг байна.

## 2.6. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

### 3. Хүснэгт 11.

/Мянган төгрөгөөр/

д/д	Тайлант он	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	
		Нэг ажилтны дундаж цалин	Орон тоо	Цалингийн сан	Нэг ажилтны дундаж цалин	Орон тоо	Цалингийн сан	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
1	2021	8,045.3	39.0	313,766.8	5,245.0	38.0	199,308.4	114,458.4	63.5
2	2022	10,882.3	32.0	348,233.4	10,752.8	29.0	311,830.7	36,402.7	89.5
3	2023	17,723.1	30.0	531,693.2	17,472.6	30.0	524,178.7	7,514.5	98.6
4	2024	18,577.7	32.0	594,486.0	16,046.9	32.0	513,499.4	80,986.6	86.4

5	2025	18,546.5	32.0	593,486.5	9,511.2	32.0	304,358.1	289,128.4	51.3
Дундаж цалин		<b>11,045.7</b>		<b>368,603.2</b>	<b>11,068.1</b>	<b>22.8</b>	<b>337,377.2</b>	<b>31,226.0</b>	<b>91.5</b>
Дүнд эзлэх хувь		130.5	-	279,719.74					

Тус үйлдвэрийн газрын цалингийн зардал 2023 оноос хойш 30.5 хувиар өссөн үзүүлэлтэй байна. байгаа боловч жил бүр цалингийн зардлын хэмнэлтийг улирлын чанартай ажлын байрны үр дүнгээр батлагдсан цалингийн зардал тогтвортой хэмнэлтэй тайлагнагдсан байна.

Албан хаагчдын цалингийн хэмжээ өсөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 12.

/Мянган төгрөгөөр/

Огноо	Үндсэн цалин				Өөрчлөлт хувиар 2022-2025
	2022	2023	2024	2025	
Хамгийн бага	660.0	825.0	990.0	1,039.5	<b>157.5</b>
Хамгийн их	1,314.5	1,971.7	2,573.5	2,796.4	<b>212.7</b>
<b>Цалингийн өсөлт</b>		<b>150.0</b>	<b>130.5</b>	<b>108.7</b>	

Дээрх хүснэгтээс харахад албан хаагчдын цалингийн өсөлт 2023 онд 50 хувиар, 2024 онд 30.5 хувиар, 2025 онд цалин хөлсний нэмэгдлийг 8.7 хувиар орлогын өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн байна. Үүнд:

2025 оны хамгийн бага үндсэн цалингийн хэмжээг 2022 онтой харьцуулахад 57.5 хувиар нэмэгдсэн бол удирдах ажилтны үндсэн цалингийн хэмжээ 2022 оноос хойш 2 дахин нэмэгдсэн байна.

### **3.1. Албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, түүнийг дүгнэж үр дүнг тооцсон эсэх**

Мандал Энерго ОНӨААТҮГ нь хүний нөөцийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын хууль, тогтоомж, эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого, хүний нөөцийн удирдлагын орчин үеийн чиг хандлага, ажилтанд тавигдах мэргэжлийн болон ёс зүйн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй байгаа нь байгууллагын гүйцэтгэл, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж, цаашдын тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлэхэд эрсдэл учруулж байна.

Тус ОНӨААТҮГ нь 2022–2025 онуудад захирлын тушаалаар бүтэц, орон тоог 30–32 ажилтан албан хаагчтай байхаар баталж, гүйцэтгэлээр 29–32 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд ажилтан бүрийг ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллуулсан байна. Гэвч ажилтан албан хаагчдын гэрээг дүгнэж, үр дүнг тооцоогүй байна.

### **3.2. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал.**

Төрийн аудитын байгууллагаас 2021-2024 онуудад хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, түүний хэрэгжилтийн биелэлтийг дараах хүснэгтээр зөрчлийн шийдвэрлэлтийн ангилал тус бүрээр биелэлтийн хамт харуулав.

**Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, шийдвэрлэлт**

Хүснэгт 13.

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн ангилал	2021		2022		2023		2024	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	2.0	8,010.4
хэрэгжилт	-	-	-	-	-	-	2.0	1,240.9
Хэрэгжилт хувь	-	-	-	-	-	-	100.0	15.5
Албан шаардлага	-		1.0	9,978.0	1.0	64,970.1	2.0	163,586.1
хэрэгжилт	-		1.0	9,978.0	1.0	64,970.1	-	-
Хэрэгжилт хувь	-	-	100.0	100.0	100.0	100.0	-	-
Зөвлөмж	4.0	96,350.0	-	-	3.0		4.0	146,464.2
хэрэгжилт	3.0	90,210.1	-	-	3.0		-	-
Хэрэгжилт хувь	75.0	93.6	-	-			-	-
<b>Нийт зөрчлийн дүн</b>	<b>4.0</b>	<b>96,350.0</b>	<b>1.0</b>	<b>9,978.0</b>	<b>4.0</b>	<b>64,970.1</b>	<b>8.0</b>	<b>318,060.7</b>
Нийт зөрчлийн хэрэгжилт	3.0	90,210.1	1.0	9,978.0	4.0	64,970.1	2.0	1,240.9
Хэрэгжилт хувь	75	93.6	100.0	100.0	100.0	100.0	100.0	15.5
<b>Аудитын дүгнэлт</b>	<b>Зөрчилгүй</b>		<b>Зөрчилгүй</b>		<b>Зөрчилгүй</b>		<b>Хязгаарлалтай</b>	

Дээрх хүснэгтээс харахад 2021-2023 онуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал нь материаллаг байдлын түвшингөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өгөгдсөн бол 2024 онд материаллаг хэмжээний зөрчилтэй тул “Хязгаарлалтай дүгнэлт өгөгдсөн байна.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар татварын тайланд 6,143.9 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан, шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, төлбөрийн цахим баримттай холбоотой 87,810.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмж өгснөөс шилэн дансанд мэдээлэл дутуу мэдээлсэн зөрчлийг давтан гаргаж 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна

Харин 2022, 2023 онуудад илэрсэн 2 албан шаардлага 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан бол 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 4 зөвлөмжийн хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

**Гурав. Дүгнэлт, шийдвэрлэлт, санал хүсэлт, зөвлөмж**

**3.1 Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- ИТХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 135 дугаар тогтоолоор баталсан тус үйлдвэрийн газрын 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд сургалт, спортын арга хэмжээний зардлыг 7,200.0 мянган төгрөгөөр баталсан атал гүйцэтгэлээр 13,669.9 мянган төгрөг зарцуулагдсан нь үйлдвэрийн газрын захирлаар ажиллаж байсан Д.Хадбаатар нь байгууллагын бүтэн жилийн сургалтын зардал болох 8,000.0 мянган төгрөгийг өөртөө давуу байдал олгож санхүүгийн шийдвэр гарган зарцуулсан гэх асуудал нь батлагдсан төсөв, гүйцэтгэлийн зардлын хэтрэлт, санхүүгийн бүртгэл тайлагнал, анхан шатны баримт, аудитын дүгнэлт зэргээр нотлогдож байна.
- Д.Хадбаатар нь тус үйлдвэрийн газрын захирлаар 2 жил гаран хугацаанд ажиллахдаа банканд 90,000.0 мянган төгрөгийн, данснаас гадуурх 160,000.0 мянган

төгрөгийн өр төлбөртэй үлдээсэн гэх асуудлыг хянан шалгахад тухайн үйлдвэрийн газар нь хамтран ажилладаг банкуудаас авсан зээл, өр төлбөрийн тооцоо байхгүй, байгууллагын санхүүгийн тайлан бүртгэлээс гадуурх 160,000.0 мянган төгрөгийн бүртгэгдээгүй өр төлбөр байгааг нотлох баримт материал гарч ирээгүй нь гүтгэлгийн шинж чанартай байж болзошгүй байна.

- Тус үйлдвэрийн газрын батлуулсан орлогын хэмжээ жил бүр 3-6 хувиар өсөн нэмэгдэж байхад зардлыг мөн 3-10 хувиар хэтрүүлж үйлдвэрийн газрын ашигт ажиллагаа, үр өгөөжийг бууруулж байна.
- Нүүрсний худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой... байх зарчмыг баримтална” гэсэн заалтын хэрэгжилтийг хангаагүй байна.
- 2024 онд орон нутгийн сонгуультай холбоотойгоор тус үйлдвэрийн газрын удирдлага солигдсон, цахилгаан эрчим хүчний үнэ, бараа материал, нүүрс, ачаа, тээврийн хөлс, ажиллах хүчний зардал зэрэг үнийн өсөлтүүд болон гүйцэтгэх удирдлагын менежмент ийг хангалтгүй зэргээс шалтгаалан тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 30,901.2 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй байна.
- Гүйцэтгэх удирдлагын зүгээс батлагдсан төсвийг зохистой удирдаагүй, санхүүгийн сахилга батыг сахиулаагүй, үйлдвэрийн газрын үр ашгийг дээшлүүлэх, зардал бууруулах, бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд төлөвлөсөн орлогын хэмжээ 3-6 хувиар давуулан биелүүлсэн атлаа олсон орлогын хэмжээгээр зарцуулсан.
- 2024 оны төлөвлөсөн зардлын нийт хэтрэлтийн 74.5 хувь болох 200,387.2 мянган төгрөгийн зарцуулалт нь өөрсдийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай буюу үр ашигтай ажиллах боломжийг алдсан байна.
- *“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь 2022-2025 онуудад 2-4 бэлтгэн нийлүүлэгчээс нүүрс худалдан авснаас байнгын тасралтгүй нийлүүлэгч нь Шивээ овоо ХХК буюу бусад нийлүүлэгчдээс тээвэр, ачилт буулгалтын зардлын өртөг шингээсэн зах зээлийн хамгийн бага үнээр нийлүүлсэн байна.*
- *Шивээ Овоо ХХК-аас тээвэр, ачилт буулгалт бусад зардлыг өртөгт шингээснээр худалдан авах нүүрсний үнэ бусад бэлтгэн нийлүүлэгчдийн зах зээлийн үнээс сүүлийн 3 жилийн худалдан авалттай харьцуулахад тонн тутамд Багануур ХХК-аас 15.0 мянган төгрөг, Ширхэнцэг арвин хишиг ХХК-аас 30.0 мянган төгрөгөөр хэмнэх боломжийг алдсан нь үйлдвэрийн газрын нүүрсний зардлыг нэмэгдүүлж үр ашиг, ашигт ажиллагааны үр нөлөөг бууруулж байна.*

### 3.2 Шийдвэрлэлт:

Төрийн аудитын байгууллагаас тус үйлдвэрийн газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлэн шийдвэрлэсэн Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын захирлаар ажиллаж байсан Д.Хадбаатарын ШУТИС-ийн сургалтын төлбөрт зарцуулсан 7,769.5 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь “Хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх” гэсэн заалтыг үндэслэн зөрчлийг давхардуулахгүй байхаар шийдвэрлэв.

### 3.3 Санал хүсэлт:

Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулахдаа түүний эрхлэх хүрээний байгууллагуудаас гүйцэтгэх засаглалыг менежментийн хангалтгүй хэрэгжүүлсэн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл учруулах, батлагдсан төсвийн зардлыг хэтрүүлсэн, авлага, өр төлбөрийг нэмэгдүүлсэн тохиолдолд гэрээгээр хүлээх үүрэг хариуцлагад түүнийг үр дүн тооцох тодорхой заалт тусган хэрэгжилтэд хяналт тавин төсвийн захирагч нарын сахилга хариуцлагыг дээшлүүлэх саналыг хүргүүлж байна.

### 3.4 Зөвлөмж:

- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжоор заасан / Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана./ шаардлагыг хангуулсны үндсэн дээр төрийн хяналт шалгалтыг хууль эрх зүйн орчинд нийцүүлэн хийхгүй бол төрийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж байгааг цаашид анхааралдаа авах
- “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр ашигт ажиллагааг дээшлүүлэхэд гүйцэтгэх удирдлагын үр нөлөөтэй байдалд томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг чиглэл өгч хариуцлагын тогтолцоог сайжруулах зөвлөмжүүдийг хүргүүлж байна.
- Санхүүгийн хяналтын шалгалтын үр дүнгээр тус үйлдвэрийн газар нь өртөг багатай нүүрсийг худалдан авах боломжийг ашиглахгүйгээр Ширхэнцэг арвин Хишиг ХХК-аас зах зээлийн өндөр үнэтэй нүүрсийг худалдан авч байгаа нь үйлдвэрийн зардлыг нэмэгдүүлж байгаад онцгой анхаарч хариу арга хэмжээг авах нь зүйтэй байна.
- Тус үйлдвэрийн газрын орлого нэмэгдүүлэх зардал бууруулах чиглэлээр дулаан ханган нийлүүлэх гэрээ байгуулсан ААНБ, айл өрхийн талбайн хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хяналтын хэрэгцээ шаардлага үүссэн байна.
- Жил бүрийн инфляцын өсөлтөөс хамаарч түүхий эд материал, цахилгаан, шатахуун, тээврийн зардлын өссөн нэмэгдэж байгаатай уялдуулан дулаан, цэвэр, бохир усны үнэ тарифыг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээг авахгүй бол орлого төвлөрүүлэлт зардлаа нөхөхгүй өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадваргүй болох эрсдэлтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:  
ДОТООД АУДИТОР  Т. ДОРЖДЭРЭМ

ХЯНАСАН:  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
СХШУАБ  Т. ОДСҮРЭН

